

**“САНАЛ ХУРААХ КУМУЛЯТИВ АРГЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ”-ЫН
ТӨСӨЛД ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧДООС САНАЛ АВЧ БАЙНА**

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэгт заасны дагуу хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн гишүүдийг сонгох харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор тус Хорооноос “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-ын төслийг шинэчлэн боловсруулж, уг төсөлд үнэт цаасны зах зээлийн оролцогчдын санаа бодлыг тусгах зорилгоор хэлэлцүүлж байна.

Иймд үнэт цаасны зах зээлийн оролцогчид журмын төсөлтэй танилцаж, саналаа өгч хамтран ажиллахыг хүсье. Та бүхэн саналаа (51)-262601 тоот утас болон avir@frc.mn цахим хаягаар өгнө үү.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНСЫН ХЭЛТЭС

2020 оны 5 дугаар сарын 14

САНАЛ ХУРААХ КУМУЛЯТИВ АРГЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

1.Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар сонгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

2.Кумулятив аргыг хэрэглэхэд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн нэг хувьцаа нь компанийн дүрмээр тогтоосон ТУЗ-ийн нийт гишүүний тоотой тэнцүү саналын эрхтэй байна.

3.Хувьцаа эзэмшигч энэ журмын 2-т заасан саналаа ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг нь, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

4.Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тусад нь тоолж, хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр тус тус сонгоно.

5.Кумулятив аргыг хэрэглэж, сонгогдсон ТУЗ-ийн нийт гишүүний гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

6.Энэ журмыг зөрчиж кумулятив аргаар ТУЗ-ийн гишүүнийг сонгосон тохиолдолд сонгуулийн дүнг хүчингүйд тооцно.

Санал хураах кумулятив аргаар санал өгөх жишээ: Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон. Хувьцаа эзэмшигч А-ийн эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100*9 гишүүн=900/ болно.

Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг нь ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.

Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгч болох буюу ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар саналаа хуваарилах эрхтэй.

Саналыг тоолох жишээ: “С” ХК-ийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрх бүхий нийт 1,000 ширхэг хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцон, ТУЗ-ийн 6 энгийн, 3 хараат бус гишүүнийг тус тус сонгохоор саналын эрхийг тоолно.

Хувьцаа эзэмшигч А - 100 ширхэг хувьцаа эзэмшдэг;
Хувьцаа эзэмшигч Б - 200 ширхэг хувьцаа эзэмшдэг;
Хувьцаа эзэмшигч В - 300 ширхэг хувьцаа эзэмшдэг;
Хувьцаа эзэмшигч Г - 400 ширхэг хувьцаа эзэмшдэг;

Саналын хуудаст 8 иргэн ердийн, 6 иргэн хараат бус гишүүнд, нийт 14 иргэн ТУЗ-ийн гишүүнд сонгогдохоор нэр дэвшиж байна /1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14 дугаар бүхий/.

Журамд зааснаар ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо ердийн болон хараат бус гишүүдээр нь зааглаж, саналын эрхийг тусад нь тоолно. Кумулятив аргыг хэрэглэхэд хуралд оролцож буй нийт хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй 1,000 ширхэг хувьцаа 9-өөр үржигдэн нийт 9,000 саналын эрх болсон.

Хүснэгтээс харахад, ТУЗ-ийн ердийн гишүүнд 1, 3, 4, 6, 7, 8 гэсэн дугаартай 6 нэр дэвшигч, хараат бус гишүүнд 9, 10, 11 гэсэн дугаартай 3 нэр дэвшигч хамгийн өндөр оноог авч сонгогдсон байна.

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	ТУЗ-ийн гишүүний тоо	Нийт саналын эрхийн тоо	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдэд өгсөн саналын эрхийн хуваарилалт								Хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд өгсөн саналын эрхийн хуваарилалт					
				1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
А	100	9	900	0	0	0	0	0	0	0	0		900	0	0	0	0
Б	200	9	1,800	900	0	0	0	0	0	0	0	900	0	0	0	0	0
В	300	9	2,700	200	0	600	0	300	300	0	200	0	0	500	0	300	300
Г	400	9	3,600	0	0	400	900	0	600	500	400	0	0	400	400	0	0
Дүн	1,000	9	9,000	1,100	0	1,000	900	300	900	500	600	900	900	900	400	600	300

---oOo---